



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/228

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон 21 аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлага сувилахуйн албадын дарга нарыг оролцуулсан төлөөллийг оролцуулсан “Сувилахуйн тусламж үйлчилгээнд удирдлагын манлайллыг сайжруулах нь” сургалтын үйл ажиллагаанд 5,000,000 (Таван сая) төгрөгийг, улсын Аварга шалгаруулах Аэробикийн тэмцээнд 10,000,000 (Арван сая) төгрөгийг, улсын Аварга шалгаруулах Ширээний теннисний тэмцээнд 10,000,000 (Арван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх “Сувилахуйн тусламж үйлчилгээнд удирдлагын манлайллыг сайжруулах нь” сургалтын үйл ажиллагаанд 5,000,000 (Таван сая) төгрөг, Улсын аварга шалгаруулах Ширээний теннисний тэмцээнд 6,000,000 (Зургаан сая) төгрөг нийт 11,000,000 (Арван нэгэн сая) төгрөгийг Эрх зүйн нийгмийн хэв журам хөтөлбөрийн Засаг даргад хуулиар олгогдсон үүрэг эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах арга хэмжээний зардлаас, Улсын аварга шалгаруулах Аэробикийн тэмцээнд 10,000,000 (Арван сая) төгрөгийг, Улсын аварга шалгаруулах Ширээний теннисний тэмцээнд 4,000,000 (Дөрвөн сая) төгрөг, нийт 14,000,000 (Арван дөрвөн сая) төгрөгийг Биеийн тамир спортын арга хэмжээний Аэробик, Ширээний теннис, таеквондогийн улсын аварга шалгаруулах тэмцээний зардлаас тус тус гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын ахлах Нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж 2024

6713010777